



2020 оны 03 дугаар сарын 04
№09 /1111/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Тэсэрч дэлбэрэх бодис,
тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд
хяналт тавих тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Шүүхийн ёс зүйн хорооны
гишүүнээр томилох тухай**

**Монгол Улсын
олон улсын
гэрээ**

**Барилгын аюулгүй байдал,
эрүүл ахуйн тухай 1988 оны
конвенц**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|---|-----|
| 122. | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 570 |
| 123. | Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 578 |
| 124. | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 578 |
| 125. | Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 579 |
| 126. | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 579 |
| 127. | Конвенц соёрхон батлах тухай | 580 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 128. | Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилох тухай | Дугаар 07 | 580 |
| 129. | Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч даргыг чөлөөлж, томилох тухай | Дугаар 08 | 581 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--------------------------------|------------|-----|
| 130. | Үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 317 | 581 |
|------|--------------------------------|------------|-----|

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- | | | |
|------|--|-----|
| 131. | Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1988 оны конвенц (№167) | 591 |
|------|--|-----|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалт:

“5.1.7.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлох хилийн боомтыг тогтоох.”

2/5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг:

“5.2.Засгийн газар энэ хуулийн 5.1.5-д заасан жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн жил бүр шинэчлэн тогтооно.”

3/6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэг:

“6.2.Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ашиг сонирхлын зөрчилтэй болон энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хамаарал бүхий этгээдийг томилохыг хориглоно.

6.3.Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын болон шинжээчийн эрх олгох, сунгах, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

4/8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт:

“8.1.4.харьяа нутаг дэвсгэр дэх энэ хуулийн 9.2-т заасан бүсийн дэглэмийг зөрчихөөс сэргийлэх арга хэмжээг иргэдийн дунд зохион байгуулах.”

5/11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалт:

“11.1.9.хуулийн этгээдийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшдэг байх.”

6/11 дүгээр зүйлийн 11.7, 11.8 дахь хэсэг:

“11.7.Энэ хуулийн 11.1.6-д заасан байгууллага хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан энэ хууль болон Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтоосон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэхэд тавих шаардлагыг хангасан эсэх талаар саналаа гаргана.

11.8.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд орсон өөрчлөлт энэ хуулийн 11.1.9-д заасан шаардлагыг хангаагүй нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.”

7/12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт:

“12.1.3.мэргэжлийн ажиллах хүчнээр хангагдсан байх.”

8/12 дугаар зүйлийн 12.4-12.6 дахь хэсэг:

“12.4.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн үндсэн түүхий эдийг импортлох тоо хэмжээг заасан зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухай бүр олгоно.

12.5.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 12.4-т заасны дагуу олгосон зөвшөөрлийн талаарх мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

12.6.Улсын хилээр нэвтрүүлж байгаа тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн үндсэн түүхий эдийг хилийн мэргэжлийн хяналтын алба бүртгэж, энэ хуулийн 22.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд тухай бүр хүргүүлнэ.”

9/14 дүгээр зүйлийн 14.8, 14.9 дэх хэсэг:

“14.8.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тоо хэмжээг тогтоосон тээвэрлэх хуудсыг тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны бэлэн байдал, даацыг харгалзан мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

14.9.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үеийн харуул хамгаалалтын зардлыг тухайн хуулийн этгээд хариуцна.”



10/15 дугаар зүйлийн 15.4-15.8 дахь хэсэг:

“15.4.Энэ хуулийн 15.2.2-т заасан байгууллага хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан энэ хууль болон Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтоосон тэсэлгээний ажил явуулахад тавих шаардлагыг хангасан эсэх талаар саналаа гаргана.

15.5.Энэ хуулийн 15.3-т заасан тайлан гаргах журмыг мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

15.6.Тэсэлгээчний эрхийг Монгол Улсын иргэнд олгох бөгөөд тэсэлгээчний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.7.Энэ хуулийн 15.2.1-д заасан мэргэжлийн ажиллах хүчинд тавих шаардлагыг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтооно.

15.8.Тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд түр агуулахыг тэсэлгээний ажил явуулах газарт тухай бүр байгуулна.”

11/17 дугаар зүйлийн 17.2-17.12 дахь хэсэг:

“17.2.Пиротехникийн хэрэгсэл үзвэрийн, эсхүл хэрэглээний зориулалттай байна.

17.3.Монгол Улсад ашиглах үзвэрийн болон хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийн жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.4.Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох хуулийн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлага тавина:

17.4.1.өөрийн эзэмшлийн газар дээр байгуулсан байнгын агуулахтай байх;

17.4.2.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй ажиллах шаардлага хангасан мэргэжлийн ажиллах хүчний талаар мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тодорхойлолт авсан байх;



17.4.3.цагдаа, тагнуулын болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байх.

17.5.Үзвэрийн зориулалттай пиротехникийн хэрэгслийг ашиглах хуулийн этгээд пиротехникийн хэрэгслийн мэргэжилтэнтэй байх бөгөөд цагдаа, тагнуулын болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байна.

17.6.Пиротехникийн хэрэгслийн мэргэжилтний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.7.Пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд үзвэрийн зориулалттай пиротехникийн хэрэгслийг энэ хуулийн 17.5-д заасан хуулийн этгээдэд худалдана.

17.8.Хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийг худалдах хуулийн этгээдэд тавих шаардлагыг энэ хуулийн 5.1.4-т заасан дүрмээр зохицуулна.

17.9.Пиротехникийн хэрэгслийг импортлох тоо хэмжээг заасан зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухай бүр олгоно.

17.10.Пиротехникийн хэрэгслийг тээвэрлэхдээ энэ хуулийн 14.7-д заасан журмын дагуу тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах бөгөөд холбогдох зардлыг хуулийн этгээд хариуцна.

17.11.Энэ хуулийн 17.4.3-т заасан байгууллага хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, ашиглахад тавих шаардлага хангасан эсэх талаар саналаа гаргана.

17.12.Улсын хилээр нэвтрүүлж байгаа пиротехникийн хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эдийг хилийн мэргэжлийн хяналтын алба бүртгэж, энэ хуулийн 22.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд тухай бүр хүргүүлнэ.”

12/22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэг:

“22.6.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцогч хуулийн этгээд болон хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас мэдээллийн нэгдсэн санд ирүүлэх мэдээллийн агуулга, давтамж, мэдээллийг баталгаажуулахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 5.1.6-д заасан журмаар зохицуулна.”



13/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:

“24.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

2 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “устгах” гэсний дараа “, тэсэлгээний ажил явуулах” гэж, мөн зүйлийн 4.1.10 дахь заалтын “дүгнэлт гаргах” гэсний дараа “эрх бүхий” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “тэсэрч дэлбэрэх бодис” гэсний өмнө “өөрийн эзэмшлийн газар дээр байгуулсан” гэж, мөн заалтын “барилга, байгууламж,” гэсний дараа “байнгын агуулах,” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “15.1” гэсний дараа “,16.1” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “стандартыг” гэсний өмнө “болон аюултай ачааны” гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “ашиглахдаа” гэсний дараа “энэ хуулийн 15.3, 15.8-д заасныг болон” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “тэсэлгээний хэрэгслийн” гэсний дараа “үйлдвэрийн байр,” гэж, мөн хэсгийн “гэрээт” гэсний өмнө “галт зэвсэг эзэмших эрх бүхий” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3 дахь заалтын “тэсэлгээний” гэсний дараа “болон пиротехникийн” гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “хуулийн этгээдэд” гэсний өмнө “тэсэлгээчин, пиротехникийн хэрэгслийн мэргэжилтний бүртгэл,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт:

“6.1.2.тэсэлгээний ажил явуулах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрлийг Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;”

2/10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг:

“10.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтооно.

10.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах нь байнгын болон түр гэсэн төрөлтэй байна. Агуулахын төрөл тус бүрд тавих шаардлага, агуулах хооронд эргэлт хийх журмыг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтооно.”

3/11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалт:

“11.1.6.цагдаа, тагнуулын болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байх;”

4/11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг:

“11.5.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд хувь нийлүүлсэн хөрөнгөд гарсан өөрчлөлтийн талаарх мэдээллээ хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш ажлын таван өдрийн дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”

5/12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт:

“12.1.1.өөрийн эзэмшлийн газар дээр байгуулсан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байнгын агуулах, ачиж буулгах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй байх;”

6/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

“12.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь тэдгээрийн үндсэн түүхий эдийг импортлох эрхтэй.”

7/15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалт:

“15.2.3.тэсэлгээний ажил явуулах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй байх.”

8/15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг:

“15.3.Тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгосон хяналтын хуудсыг үндэслэн үйл ажиллагаа явуулах бөгөөд тэсэлгээний ажлын гүйцэтгэлийн тайланг мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Тайланд тэсэлгээний ажлын тохиолдол бүрийг тусгана.”

9/16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг:

“16.1.Энэ хуулийн 15.2.1, 15.2.3-т заасан шаардлагыг хангасан тэсэлгээний ажил явуулах нэгжтэй, өөрийн эзэмшлийн газар дээр байгуулсан байнгын агуулахтай дараах хуулийн этгээд нь үндсэн үйл



ажиллагаагаа хэрэгжүүлэх зорилгоор тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл эзэмшиж болно:

16.1.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.5, 15.10.6, 15.10.18, 15.10.20, 15.15.1, 15.18.5, 15.18.6-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч;

16.1.2.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.15.4-т заасан автозам, замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрөл эзэмшигч;

16.1.3.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.14.6-д заасан барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч.”

10/17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг:

“17.1.Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах болон аюулгүй ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулийн 5.1.4-т заасан дүрмээр зохицуулна.”

11/20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт:

“20.1.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.6, 11.1.7 дахь заалт болон энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй хуулийн этгээдэд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох болон пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл олгох;”

12/23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг:

“23.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд дараах байгууллага хяналт тавина:

23.1.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомжийн биелэлтэд мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

23.1.2.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний болон пиротехникийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхэд хилийн мэргэжлийн хяналтын алба;

23.1.3.пиротехникийн хэрэгслийн худалдаа, үзвэрийн зориулалтаар ашиглах үеийн аюулгүй байдалд цагдаа, онцгой байдлын

болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

23.1.4.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, хадгалалтын үеийн галын аюулгүй байдал, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага.”

4 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “гүйцэтгэх” гэснийг “явуулах” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “бүс, түүний дэглэмийг” гэснийг “бүсийг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “бүсийг” гэснийг “бүс, түүний дэглэмийг” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “Зэвсэгт хүчний жанжин штабын санал” гэснийг “онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг” гэж, мөн зүйлийн 12.3.4 дэх заалтын “10 өдрийн дотор” гэснийг “20 өдрийн дотор” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн” гэснийг “Онцгой байдлын асуудал хариуцсан” гэж, 15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалтын “санал, дүгнэлтийг” гэснийг “саналыг” гэж, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “24 цагийн дотор” гэснийг “даруй” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн” гэснийг “онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “гамшгаас хамгаалах” гэснийг “онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтын, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “санал,” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтын “зориулалтын агуулах,” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “онц” гэснийг, мөн зүйлийн 14.7 дахь хэсгийн “үед мөрдөх” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “иргэн,” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад долоо хоногийн дотор хүргүүлж,” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх хэсгийг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг, 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Гаалийн тухай хуулийн 236 дугаар зүйлийн 236.5 дахь хэсэгт “Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон аюултай бодис, орчиндоо аюул учруулж болох бусад бараанд аюулгүй байдлыг хангасны дараа гаалийн шалгалт хийнэ.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.4 дэх заалтын “үйлдвэрлэх,” гэсний дараа “пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.4 дэх заалтын “худалдах” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “Химийн” гэснийг “Тэсэрч дэлбэрэхээс бусад химийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.1.12 дахь заалт нэмсүгэй:

“25.1.12.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 17 дугаар зүйлийн 17.9-д заасан зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгоход 100 000 төгрөг.”

2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтын “худалдах” гэсний дараа “, хэрэглээний пиротехникийн хэрэгсэл худалдах” гэж, мөн зүйлийн 25.1.4 дэх заалтын “үйлдвэрлэх,” гэсний дараа “импортлох, экспортлох,” гэж, мөн заалтын “төгрөг” гэсний дараа “, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 1 250 000 төгрөг” гэж тус тус нэмсүгэй.



3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.27 дахь заалтын “9.4-т” гэснийг “12.4, 17.9-д” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын “Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 1988 оны 167 дугаар конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 02 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Лхагвасүрэнгийн Галбаатар, Тэрбишийн Мөнх-Эрдэнэ нарыг Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 02 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч даргыг чөлөөлж, томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Зэвсэгт хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.14 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Хошууч генерал Раднаабазарын Сүхбатыг Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч даргын албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Хуурай замын цэргийн командлалын ажиллагааны дэмжлэгийн хэлтсийн дарга, хурандаа Цэвэлмаагийн Жавхланбаатарыг Зэвсэгт хүчний жанжин штабын нэгдүгээр орлогч даргын албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 08 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 317

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцын 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн а, хавсралт В-ын 1, 2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.



3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран баталж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд баггаан Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

У.ХҮРЭЛСҮХ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Н.ЦЭРЭНБАТ

Засгийн газрын 2019 оны
317 дугаар тогтоолын хавсралт

**АЛТНЫ БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС
ҮҮДЭЛТЭЙ МӨНГӨН УСНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Ерөнхий мэдээлэл

Мөнгөн ус болон түүний нэгдэл агуулсан хаягдал нь хүрээлэн байгаа орчныг ноцтой бохирдуулж, хүн, мал, амьтны биед амьсгалын зам, арьс болон хоол хүнс, идэш, тэжээлээр дамжин нэвчин орж, амьсгалын тогтолцоо, нүд, арьс салстыг хордуулж, бөөр, нөхөн үржихүй, төв мэдрэлийн системийг гэмтээж удаан хугацааны туршид хордуулдаг онцгой хортой бодис юм. Нэгдсэн Үндэстний Байгууллага 2013 онд Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцыг боловсруулан баталсан бөгөөд энэхүү конвенц нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн ус болон түүний нэгдлийн ялгарал, хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах үндсэн зорилготой.

Монгол Улсын Их Хурал 2015 оны 4 сарын 30-ны өдөр Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцыг соёрхон баталж, нэгдэн орсон. Конвенцын 7 дугаар зүйлийн 4 хэсгийн а, мөн хавсралт В-д заасны дагуу гишүүн орнууд гар аргаар болон алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны хэрэглээг таслан зогсоох, түүнээс байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл, бохирдлыг бууруулахад чиглэсэн үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

2010 онд Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг батлан хэрэгжүүлснээр бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн. Уг журамд нь бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөрийн болон байгаль орчны аюулгүй ажиллагааг хангах, нэгдсэн зохион байгуулалтад нөхөрлөл хэлбэрээр оруулж, бүртгэлжүүлэх зохицуулалтыг тусгасан.

Үндэсний статистикийн хорооноос 2016 онд хийсэн судалгаагаар 15 аймгийн нийт 34 сумд, Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт алтны бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж, 5108 иргэн алтны бичил уурхай эрхэлж байгаагаас, 1415 нь хувиараа буюу хууль бусаар алт олборлож байна. Иргэд бичил уурхай нэрээр хууль бусаар ашигт малтмал олборлохдоо Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт бодис ашиглан байгаль орчныг бохирдуулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуйн стандарт, норм, дүрмийг зөрчин үйл ажиллагаа явуулж байна.

Түүнчлэн Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолоор мөнгөн ус болон мөнгөн усны органик, органик бус нэгдлүүдийг Монгол Улсад ашиглахыг хязгаарласан, Байгаль орчны сайдын 2008 оны тушаалаар мөнгөн усыг ашигт малтмалын олборлолт, боловсруулалтад ашиглахыг хориглосон хэдий ч сүүлийн жилүүдэд алтны бичил уурхайн үйл ажиллагаанд хууль бусаар мөнгөн ус хэрэглэх, мөнгөн усны худалдаа, хэрэглээ далд хэлбэрт явагдаж байж болзошгүй зөрчил олноор гарч байна.

Эрүүл мэндийн байгууллагаас 2012, 2014 онуудад алтны үндсэн орд бүхий 12 сумын 308 алтны бичил уурхай эрхлэгч иргэдийн дунд хийсэн “Гар аргаар алт олборлогчдын мөнгөн усны хэрэглээ, түүний эрүүл мэндийн нөлөөллийг судалгаа”-гаар судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын цус, шээсэн дэх мөнгөн усны агууламж 14.3-24.5 хувьд буюу түгшүүр төрүүлэх, шуурхай арга хэмжээ авах шаардлагатай түвшинд хүрсэн нь илэрсэн. Эдгээр тоо баримт нь бичил уурхай эрхлэгчид алт олборлох үйл ажиллагаанд мөнгөн усыг хууль бусаар хэрэглэсээр байгааг харуулж байна. Мөн манай улсад одоогийн байдлаар хууль бус ашиглалтаас хураагдсан мөнгөн усыг түр хадгалах зориулалтын орчин нөхцөл бүрдээгүй байна.

Иймд цаашид алтны бичил уурхайн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, мөнгөн усны байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл, нөлөөллийг бууруулж, хариуцлагатай бичил уурхайг төлөвшүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалт”-ын 66-д Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр боловсруулан батлуулахаар заасныг үндэслэн уг үндэсний хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг боловсрууллаа.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго

Алтны бичил уурхайгаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулж, хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг ханган, хүн амын эрүүл,



аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

2.2.1. гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагаанд ашиглаж байгаа хүний эрүүл мэнд, байгаль орчинд халтай хоцрогдсон технологийг бүрэн халах, мөнгөн усны хууль бус худалдаа, хэрэглээг таслан зогсоох замаар бичил уурхайгаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, мөнгөн усны ялгарлыг өнөөгийн түвшинтэй харьцуулахад 50-иас доошгүй хувиар бууруулах;

2.2.2. гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагааг зохицуулах төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой болгож, салбар дундын зохицуулалт, талуудын оролцоо, хамтын ажиллагааг уялдуулж, чадавхыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

2.2.3. гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлогчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, хүүхэд, эмэгтэйчүүд, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүдийг мөнгөн усны сөрөг нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, 2023 он гэхэд алтны бичил уурхайчдын 80-аас доошгүй хувийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулж, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх;

2.2.4. алтны бичил уурхайгаас үүдэлтэй сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй хүн ам, бичил уурхайчдад мөнгөн усны сөрөг нөлөөлөл, байгаль орчин, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хууль тогтоомжийн талаар мэдлэг олгож, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагаанд ашиглаж байгаа хүний эрүүл мэнд, байгаль орчинд халтай хоцрогдсон технологийг бүрэн халах, мөнгөн усны хууль бус худалдаа, хэрэглээг таслан зогсоох замаар бичил уурхайгаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, мөнгөн усны ялгарлыг өнөөгийн түвшинтэй харьцуулахад 50-иас доошгүй хувиар бууруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох, баяжуулах үйл ажиллагаанд ашиглаж байгаа хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөтэй технологи, арга ажиллагааг халах;

3.1.2. гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох, баяжуулах үйл ажиллагааны улмаас үүсч болзошгүй мөнгөн усны ялгарал, бохирдлын төлөв байдалд хяналт шинжилгээ, хүн амын мөнгөн усанд өртөх эрсдэлийн судалгаа хийж, мөнгөн усаар бохирдсон газрыг саармагжуулж, нөхөн сэргээлт хийж;

3.1.3. мөнгөн усны хууль бус худалдаа, алтны бичил уурхай дахь мөнгөн усны далд хэрэглээг илрүүлж, таслан зогсоох.

3.2. Гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагааг зохицуулах төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой болгож, салбар дундын зохицуулалт, талуудын оролцоо, хамтын ажиллагааг уялдуулж, чадавхыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. бичил уурхайн талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгож, хариуцлагын механизмыг чангатгах, бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх салбар дундын зохицуулалтыг уялдуулж, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох;

3.2.2. холбогдох төрийн захиргааны байгууллагын чадавх, судалгаа, шинжилгээний байгууллага, лабораторийн материаллаг баазыг бэхжүүлэх;

3.2.3. шударга, хариуцлагатай алт олборлолтыг дэмжсэн зах зээлийн аргуудыг нэвтрүүлэх, чадавхжуулах.

3.3. Гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлогчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, хүүхэд, эмэгтэйчүүд, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүдийг мөнгөн усны сөрөг нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, 2023 он гэхэд алтны бичил уурхайчдын 80-аас доошгүй хувийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулж, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. төрөөс эрүүл мэндийн талаар баримталж байгаа бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлогчид, тэдний гэр бүлийн гишүүдийг хамруулж, эрүүл мэндийг хамгаалах;

3.3.2. гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлогчид, тэдний гэр бүлийн гишүүд, хүүхэд, эмэгтэйчүүд, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүдийг мөнгөн усанд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх;

3.3.3. мөнгөн усны хор хөнөөл, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, мөнгөн усны өртөлтөөс сэргийлэх, алтны бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар мэдлэг олгох, мэдээлэл түгээх;

3.3.4. алтны бичил уурхайд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны норм, дүрмийн хэрэгжилтийг сайжруулж, осол, гэмтлийг бууруулах.

3.4. Алтны бичил уурхайгаас үүдэлтэй сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй хүн ам, бичил уурхайчдад мөнгөн усны сөрөг нөлөөлөл, байгаль



орчин, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хууль тогтоомжийн талаар мэдлэг олгож, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. цахим платформ, нийгмийн сүлжээ, орон нутгийн хэвлэл мэдээллийн сувгуудыг ашиглан хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, байгальд ээлтэй, мөнгөн усгүй технологи, мөнгөн усны хор хөнөөл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын талаарх мэдээллийг гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлогчид хүргэх;

3.4.2. төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, мөнгөн усны хор хөнөөл, эрүүл мэнд, эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, үйлчилгээний талаар мэдлэг олгох сургалтыг системтэй зохион байгуулах;

3.4.3. төрийн болон төрийн бус байгууллага, боловсролын байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн оролцоотойгоор алтны бичил уурхайчдыг эдийн засгийн өөр салбарт зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх.

Дөрөв.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

4.1 Хөтөлбөрийг 2019-2023 онд дараах 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

4.1.1. I үе шат: 2019-2020 он;

4.1.2. II үе шат: 2021-2023 он.

Тав. Хөтөлбөрийн үр дүн

5.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна:

5.1.1. хууль бус алт олборлолт, мөнгөн усны хууль бус хэрэглээ буурч, алтны бичил уурхайн үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтын хүрээнд явуулж, уг үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө буурч, хариуцлагатай бичил уурхай төлөвшинө;

5.1.2. алтны бичил уурхайн асуудлаар төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үйл явцад төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоо нэмэгдэж, төрийн байгууллагаас гарах аливаа шийдвэр нь харилцан уялдаатай хэрэгжих нөхцөл бүрдэнэ;

5.1.3. байгаль орчныг хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, орчны бохирдол, химийн бодисын хор, аюулаас эрүүл мэндээ хамгаалах чиглэлээр алтны бичил уурхайчид, иргэдийн мэдлэг, ойлголт сайжирна;

5.1.4. хүн амын эмзэг бүлэг тухайлбал хүүхэд, эмэгтэйчүүд, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд мөнгөн усны болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон гэр бүл, ойр дотны хүмүүсээ хамгаалах чадавх сайжирч, гэмтэл, хордлого, өвчлөл буурна;



5.1.5. орон нутагт ажлын байр бий болж иргэдийн амьжиргаанд хувь нэмэр оруулан, төсвийн орлогын бүрдэлтэд эерэгээр нөлөөлнө;

5.1.6. бичил уурхайн үйл ажиллагааны болзошгүй эрсдэл, орчны бохирдлоос иргэд өөрийн эрүүл мэнд, амьдрах орчноо хамгаалах, түүний үр нөлөөг бууруулах чадвар, зөв дадал хэвшилтэй болж, байгаль орчин, эрүүл мэндийн улмаас учрах эдийн засгийн хохирол буурна;

5.1.7. хариуцлагатай алтны бичил уурхайн үйл ажиллагаа төлөвшсөнөөр хүний эрүүл мэнд, байгаль орчинд халтай хоцрогдсон технологийг халж, нөөцийг хаягдал, бохирдол багатай бүрэн ашиглаж, эдийн засгийн үр өгөөж нэмэгдэнэ;

5.1.8. хүрээлэн байгаа орчныг хамгаалах, хууль дээдлэх, уламжлалт ёс заншлаа хүндэтгэх талаар гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлогч иргэдийн ухамсар дээшилснээр хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил багасч, төсвийн зардал буурна.

Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

6.1. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2017)	Хүрэх түвшин (2023)	Мэдээллийн эх сурвалж	Хариуцах байгууллага
Хөтөлбөрийн зорилт 1. Гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагаанд ашиглаж байгаа хүний эрүүл мэнд, байгаль орчинд халтай хоцрогдсон технологийг бүрэн халах, мөнгөн усны хууль бус худалдаа, хэрэглээг таслан зогсоох замаар бичил уурхайгаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, мөнгөн усны ялгарлыг өнөөгийн түвшинтэй харьцуулахад 50-иас доошгүй хувиар бууруулах						
1	(Боломжит арга технологи) (Байгальд ээлтэй практик) нэвтрүүлсэн алт баяжуулах цех	тоо	1	8	https://www.asmhub.mn/mn/home	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар
2	Мөнгөн усны бохирдлын судалгаа хийсэн сум (үндсэн орд бүхий)	тоо	2	9	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
3	Алтны бичил уурхайгаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг цэвэрлэж, саармагжуулсан нөхөн сэргээсэн талбайн хэмжээ	гектар	60	90-ээс доошгүй	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ашигт малтмал, газрын тосны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
4	Мөнгөн устай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн бууралт	хувь	-	50	Цагдаагийн ерөнхий газар	Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар



5	Алтны бичил уурхай дахь мөнгөн усны болзошгүй хэрэглээ (Олон улсын аргачлалаар тооцсон 2018 он)	кг	235.4	117.5	Алтны бичил уурхай дахь мөнгөн усны тооллого, судалгаа	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Хөтөлбөрийн зорилт 2. Гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлох үйл ажиллагааг зохицуулах төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой болгож, салбар дундын зохицуулалт, талуудын оролцоо, хамтын ажиллагааг уялдуулж, чадавхыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах						
6	Чадавх бэхжүүлэх арга хэмжээнд хамрагдсан төв болон орон нутгийн төрийн байгууллагын ажилтан	тоо	280	500-аас багаргүй	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
7	Хууль, тогтоомжийн дагуу алтны бичил уурхай эрхлэгч иргэд	хувь	72.7	100	Үндэсний статистикийн хороо	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
8	Бичил уурхайгаар олборлосон алтны хэмжээ	тонн	212	125.2	Үндэсний статистикийн хороо	Монголбанк
9	Бичил уурхайгаар олборлосон эко алтны хэмжээ	кг	2	6	Монголбанк	Монголбанк
10	Орон нутагт шинээр байгуулсан үнэт металлын сорьцын салбар лаборатори	тоо	1	2	Монголбанк	Монголбанк
Хөтөлбөрийн зорилт 3. Гар аргаар болон бичил уурхайгаар алт олборлогчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, хүүхэд, эмэгтэйчүүд, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүдийг мөнгөн усны сөрөг нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, 2023 он гэхэд алтны бичил уурхайчдын 80-аас доошгүй хувийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулж, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх						
11	Алтны үндсэн орд бүхий сумдын урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан алтны бичил уурхайчин эмэгтэйчүүд	хувь	-	80	Эрүүл мэндийн яам	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
12	Алтны бичил уурхай бүхий сумдын алт олборлох үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдийн бэртэл, гэмтэл	хувь	66.7	0	Үндэсний статистикийн хороо	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар

13	Хорт бодист өртсөн хүүхэд	хувь	2.6	0	Үндэсний статистикийн хороо	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар,
14	Мөнгөн усны хордлогыг оношлох, хордлогоос үүдэлтэй бие, сэтгэцийн өөрчлөлт, өвчлөлийг эмчлэхэд чиглэсэн сургалт	тоо	-	20	Эрүүл мэндийн яам	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
15	Мөнгөн усны хордлогыг оношлох, хордлогоос үүдэлтэй бие, сэтгэцийн өөрчлөлт, өвчлөлийг эмчлэхэд чиглэсэн сургалтад хамрагдсан орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд	тоо	-	150	Эрүүл мэндийн яам	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
16	Мөнгөн усны хор, хөнөөл, өртөлтийн чиглэлээр орон нутагт зохион байгуулсан мэдлэг олгох арга хэмжээ, арга хэмжээнд хамрагдсан орон нутгийн иргэд	тоо	360	5000	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Аймаг, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар
17	Алт олборлогч иргэдийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл хэрэглэдэг байдал	хувь	75.6	95.6	Үндэсний статистикийн хороо	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
Хөтөлбөрийн зорилт 4. Алтны бичил уурхайгаас үүдэлтэй сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй хүн ам, бичил уурхайчдад мөнгөн усны сөрөг нөлөөлөл, байгаль орчин, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хууль тогтоомжийн талаар мэдлэг олгож, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх						
18	Бичил уурхайн мэдлэгийн төвийн цахим сайтад байршуулсан мөнгөн усны хор нөлөө болон мөнгөн усгүй, байгальд халгүй технологийн мэдээлэл	тоо	20	100	https://www.asmhub.mn/mn/home	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам



19	Бичил уурхайн мэдлэгийн төвийн онлайн хандалтын өсөлт	хувь	-	75-аас доошгүй хувь	https://www.asmhub.mn/mn/home	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
20	Хууль эрх зүй, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр сургалтад хамрагдсан мэргэжлийн зөвлөгөө авсан алтны бичил уурхай эрхлэгчид	хувь	17	60	Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар
21	Бичил уурхайгаас өөр салбарт шилжиж хөдөлмөр эрхэлсэн хүн	тоо	-	700	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг дараах хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

7.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

7.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;

7.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, хөрөнгө;

7.1.4. бусад эх үүсвэр.

Найм. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах асуудлаар төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий салбар дундын зөвлөл ажиллана. Тус зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

8.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангана.

8.3. Төрийн захиргааны төв байгууллага, төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь салбарын, нутаг дэвсгэрийн болон байгууллагын хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн

жилийн төлөвлөгөө, төсөвт тусгах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд гаргах үүрэг хүлээнэ.

8.4. Бичил уурхайн төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, бичил уурхай эрхлэгч иргэд хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, чадавх бэхжүүлэх сургалтууд, эрүүл мэндийн судалгаанд хамрагдана.

**Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн
хяналт-шинжилгээ, үнэлгээ**

9.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох журмын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

9.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь жил бүр холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулна.

9.3. Мөнгөн усны тухай Миниматагийн конвенцоор хүлээсэн үүргийн дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг конвенцын тайланд тусган 3 жилд нэг удаа Минаматагийн конвенцын нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлнэ.

9.4. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

**БАРИЛГЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ 1988 ОНЫ КОНВЕНЦ (№167)**

Оршил

Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын Ерөнхий бага хурал нь, Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөлөөс 1988 оны 6 дугаар сарын 1-нд Женев хотноо зарлан хуралдуулсан далан тав дугаар чуулганаараа,

Холбогдох олон улсын хөдөлмөрийн конвенц, зөвлөмж, тэр дундаа Барилгын аюулгүй байдлын тухай 1937 оны конвенц, зөвлөмж, Барилгын ослоос урьдчилан сэргийлэх тухай хамтын ажиллагааны 1937 оны зөвлөмж, Цацрагаас хамгаалах тухай 1960 оны конвенц, зөвлөмж,



Машин механизмыг хамгаалах тухай 1963 оны конвенц, зөвлөмж, Жингийн дээд хязгаарын тухай 1967 оны конвенц, зөвлөмж, Ажил, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн тухай 1974 оны конвенц, зөвлөмж, Агаарын бохирдол, дуу чимээ, чичирхийлэлийн асуудлаарх ажлын байрны орчны тухай 1977 оны конвенц, зөвлөмж, Ажил, мэргэжлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1981 оны конвенц, зөвлөмж, Ажил, мэргэжлийн эрүүл мэндийн үйлчилгээний тухай 1985 оны конвенц, зөвлөмж, Асбестос ашиглах тухай 1986 оны конвенц, зөвлөмж болон Хөдөлмөрийн ослын тэтгэмжийн тухай 1964 оны конвенцид 1980 онд шинэчлэгдэн туссан ажил, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн жагсаалтыг тэмдэглэж,

Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх тодорхой саналыг чуулганы хэлэлцэх хэргийн дөрөв дүгээр зүйлээр батлахаар шийдвэрлэж,

Энэхүү санал нь Барилгын аюулгүй байдлын тухай 1937 оны конвенцыг дахин боловсруулахаар зорьж,

Нэг мянга есөн зуун наян найман оны зургаадугаар сарын хорины өдөр Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1988 оны конвенц гэж нэрлэгдэх дараах конвенцыг батлав.

I. ХАМРАХ ХҮРЭЭ, ТОДОРХОЙЛОЛТ

1 дүгээр зүйл

1. Энэхүү конвенц нь барилгын инженер, барилга угсралт, буулгалт, түүнчлэн барилгын талбай дахь бүх үйл явц, үйл ажиллагаа, тээвэрлэлт болон талбай дахь бэлтгэл ажлаас төсөл дуусах хүртэлх барилгын бүхий л үйл явцад хэрэглэгдэнэ.

2. Энэхүү конвенцыг баталж буй гишүүн улс нь ажил олгогч ба ажилтныг төлөөлөгч газар хэрэв байгаа бол тэдгээртэй зөвлөлдсөний дараа ажил эрхлэлтийн аюулгүй байдал, эрүүл мэндийн нөхцөлийг хангасан тохиолдолд зарим заалт, тухайлбал эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой салбарын тодорхой ажлыг хийхээс татгалзах, эсхүл холбогдох заалтыг конвенцоос хасч болно.

3. Энэхүү конвенц нь үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд тусгасан хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд мөн хэрэглэгдэнэ.

2 дугаар зүйл

Энэхүү конвенцын зорилго нь:

(а) “Байгууламж” гэх нэр томъёо нь дараахыг хамарна. Үүнд:

(i) барилга, тэр дундаа газар шорооны ажил, барилга угсралтын ажил, бүтцийн өөрчлөлт, барилгын өргөтгөл шинэчлэл, засвар үйлчилгээ (тэр дундаа цэвэрлэгээ болон будаг) болон бүх төрлийн барилга, эсхүл байгууламжийг нураах;

(ii) иргэний барилга, тэр дундаа газар шорооны ажил, барилга угсралтын ажил, бүтээцийн өөрчлөлт, засвар үйлчилгээ, угсралт болон

нураалт, жишээлбэл, харилцаа холбоо, ус зайлуулах, ариутгах суваг, ус болон эрчим хүчний хангамж зэрэг үйлчилгээтэй холбоотой нисэх онгоцны буудал, усан онгоцны зогсоол, эргийн зогсоол, газар хоорондын усан зам, далан, гол, нуранги, далайн хамгаалалтын ажил, зам, хурдны зам, төмөр зам, гүүр, нүхэн гарц болон давхар зам;

(iii) угсармал барилга, байгууламжийн угсралт, буулгалт, түүнчлэн барилгын талбайд угсармал эдлэлийг үйлдвэрлэх;

(b) “Барилгын талбай” гэх нэр томьёо нь (a) дэд хэсэгт тодорхойлсон бүх үйл явц, үйл ажиллагааг гүйцэтгэж буй талбайг хэлнэ;

(c) “Ажлын байр” гэх нэр томьёо нь (e) дэд хэсэгт тодорхойлсон ажил олгогчийн хяналтан дор өөрийн ажлыг хийхээр очих, эсхүл байх ёстой бүх газрыг хэлнэ;

(d) “Ажилтан” гэх нэр томьёо нь барилгын үйл ажиллагаанд оролцож буй хүнийг хэлнэ;

(e) “Ажил олгогч” гэх нэр томьёо нь дараахыг хэлнэ. Үүнд:

(i) Барилгын талбайд нэг болон түүнээс дээш тооны ажилтныг ажиллуулж буй бие хүн, эсхүл хуулийн этгээд;

(ii) Нөхцөл байдлаас хамааран ерөнхий гүйцэтгэгч, гүйцэтгэгч, эсхүл туслан гүйцэтгэгч;

(f) “Эрх бүхий этгээд” гэх нэр томьёо нь тодорхой ажлыг аюулгүй хийж гүйцэтгэх зохих чадвартай, тухайлбал хангалттай дадлага туршлагатай, зохих сургалтад суусан, мэдлэг бүхий мэргэшсэн хүнийг хэлнэ. Эрх бүхий байгууллага тэдгээр эрх бүхий этгээдийг томилоход зохих шалгуур, ажил үүргийг тодорхойлж болно;

(g) “Түшиц хэрэгсэл” гэх нэр томьёо нь (h) дэд хэсэгт тодорхойлсон “өргөх төхөөрөмж”-өөс бусад аливаа барилга, байгууламжид гарах, ажилтан болон эд материалыг байрлуулахад дэмжлэг үзүүлэх зөөврийн, дүүжин, угсардаг түр зуурын байгууламжийг хэлнэ;

(h) “Өргөх механизм” гэх нэр томьёо нь хүн, эсхүл ачааг өргөх, эсхүл буулгахад ашигладаг аливаа суурин болон хөдөлгөөнт механизмыг хэлнэ;

(i) “Өргөх тоног төхөөрөмж” гэх нэр томьёо нь өргөх механизмд залгагдсан гэхдээ өргөх механизмын нэг хэсэг биш, аливаа тоног төхөөрөмж эсвэл хийцийг хэлнэ.

II. ЕРӨНХИЙ ЗААЛТ

3 дугаар зүйл

Энэхүү конвенцын заалтыг хэрэгжүүлэхээр авах арга хэмжээний талаар ажил олгогч болон ажилтныг төлөөлөгч газартай зөвлөлдөнө.



4 дүгээр зүйл

Энэхүү конвенцыг баталж буй гишүүн улс бүр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг үндэслэн конвенцын заалтыг хангах хууль тогтоомж, эсхүл журмыг баталж, мөрдөнө.

5 дугаар зүйл

1. Дээрх 4 дүгээр зүйлд заасны дагуу баталсан хууль тогтоомж, эсхүл журмыг практик хэрэглээнд нэвтрүүлэхдээ дотоодын нөхцөл байдал болон хэрэглээнд нийцсэн техникийн стандарт, эсхүл хэрэглээний дүрэм, эсхүл өөр бусад зохих аргаар хэрэгжүүлж болно.

2. Дээр дурдсан 4 дүгээр зүйл болон энэ заалтын 1 дэх хэсгийг хэрэгжүүлэхдээ гишүүн улс бүр стандартчиллын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын байгууллагын баталсан холбогдох хэм хэмжээ, стандартыг харгалзан үзнэ.

6 дугаар зүйл

Барилгын талбай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйг дэмжих зорилгоор үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд тодорхойлсон зохицуулалтын дагуу ажил олгогч болон ажилтны хамтын ажиллагааг хангах арга хэмжээ авна.

7 дугаар зүйл

Үндэсний хууль тогтоомж, эсхүл журмаар ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг дагаж мөрдөхийг шаардана.

8 дугаар зүйл

1. Хоёр ба түүнээс дээш тооны ажил олгогч нэг барилгын талбайд зэрэг үйл ажиллагаа явуулах үед:

(а) Барилгын талбайн нийт үйл ажиллагааны үндсэн үүргийг хэрэгжүүлж буй ерөнхий гүйцэтгэгч, эсхүл барилгын талбайн ерөнхий үйл ажиллагаанд бодит хяналт тавьдаг бусад этгээд, эсхүл байгууллага нь үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд нийцсэн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг дагаж мөрдүүлэх, тэдгээр арга хэмжээг хангах үүрэгтэй.

(б) Үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд нийцэж байгаа тохиолдолд хэрэв барилгын талбайн үйл ажиллагааг бүхэлд нь хариуцах үндсэн гүйцэтгэгч, эсхүл барилгын талбайн ерөнхий үйл ажиллагаанд бодит хяналт тавьдаг бусад этгээд, эсхүл байгууллага барилгын талбайд байхгүй үед (а) дэд хэсэгт заасан арга хэмжээг дагаж мөрдүүлэх, арга хэмжээг хангах эрх бүхий хуулийн этгээд, эсхүл байгууллагыг өөрийн өмнөөс нэр дэвшүүлнэ.

(с) Ажил олгогч бүр өөрийн удирдлага доор ажиллаж байгаа ажилтанд хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг байнга хүлээнэ.

2. Нэг барилгын талбайд зэрэг ажиллаж буй ажил олгогч, эсхүл хувиараа хөдөлмөр эрхлэгч нь үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд тодорхойлсон аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.

9 дүгээр зүйл

Барилгын төслийн зураг төсөл, төлөвлөлтийг хариуцсан этгээд нь үндэсний хууль тогтоомж, журам болон практикийн дагуу барилга дахь ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийг харгалзан үзнэ.

10 дугаар зүйл

Ажилтан нь аливаа ажлын байранд ажлын тоног төхөөрөмж, арга барилд хяналт тавих, аюулгүй байдал, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй баталсан ажлын үйл явцын талаар санал бодлоо илэрхийлэх зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд оролцох эрхийг үндэсний хууль тогтоомж, эсхүл журмаар олгоно.

11 дүгээр зүйл

Үндэсний хууль тогтоомж, эсхүл журам нь ажилтанд дараах эрх үүргийг олгоно. Үүнд:

(а) тодорхойлсон аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхэд ажил олгогчтой аль болох нягт хамтран ажиллах;

(б) үйл ажиллагаа, ажлын байран дахь осол, эндэгдэлд өртөж болзошгүй өөрийн болон бусдын аюулгүй байдал, эрүүл мэндийг сахин хамгаалах;

(с) багаж хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах, мөн өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангахад зориулсан багаж хэрэгслийг буруугаар ашиглахгүй байх;

(д) аюултай байдал үүссэн байж болзошгүй, мөн түүнийг бие даан шаардлагатай түвшинд шийдэх боломжгүй гэж үзсэн аливаа нөхцөлд өөрсдийн шууд удирдлага, мөн ажилтны аюулгүй байдлыг хариуцсан төлөөлөгчдийн аль байгаад нь яаралтай мэдэгдэх;

(е) тодорхойлсон аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг дагаж мөрдөх.

12 дугаар зүйл

1. Ажилтан өөрийн аюулгүй байдал, эсхүл эрүүл мэндэд гэнэтийн, ноцтой аюул учирна гэж үзэх үндэслэлтэй бол тухайн аюулаас зайлсхийх эрхтэй бөгөөд өөрийн удирдлагад энэ талаар шуурхай мэдэгдэх үүргийг үндэсний хууль тогтоомж, эсхүл журмаар олгоно.

2. Ажилтны аюулгүй байдалд гэнэтийн аюул учирсан тохиолдолд ажил олгогч нь тухайн ажлыг нэн даруй зогсоож, ажилтныг зохих ёсоор нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авна.



III. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

13 дугаар зүйл АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

1. Бүх ажлын байр нь аюулгүй, ажилтны аюулгүй байдал болон эрүүл мэндэд гэмтэл учруулах эрсдэлгүй байх шаардлагатай бүхий л урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна.

2. Бүх ажлын байранд аюулгүй нэвтрэх болон гарах нөхцөлийг хангасан, мөн шаардлагатай бол тэдгээрийг заасан тэмдэглэгээтэй байна.

3. Барилгын талбай дээр гарч болох бүх эрсдэлээс барилгын талбай дээр болон түүний эргэн тойронд байгаа хүмүүсийг хамгаалах урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авсан байна.

14 дүгээр зүйл ТҮШИЦ ХЭРЭГСЭЛ БОЛОН ШАТ

1. Газарт, эсхүл газраас дээш, эсхүл барилга, эсхүл бусад суурин байгууламжийн аль нэг хэсгээс ажлыг аюулгүй гүйцэтгэх боломжгүй үед аюулгүй, зохимжтой түшиц хэрэгслээр хангасан болон байршуулсан байх, эсхүл бусад аюулгүй болон зохимжтой арга хэмжээг авсан байна.

2. Өндөрт ажиллах ажлын байранд аюулгүй нэвтрэх өөр нөхцөл байхгүй үед зохимжтой шатаар хангасан байна. Тэдгээрийг хөдлөхөөс сэргийлж хамгаалсан байна.

3. Бүх түшиц хэрэгсэл болон шатыг үндэсний хууль тогтоомж, эсхүл журмын дагуу угсарч ашиглана.

4. Түшиц хэрэгслийг үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд заасан нөхцөл, хугацаанд эрх бүхий этгээд шалгасан байна.

15 дугаар зүйл ӨРГӨХ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН МЕХАНИЗМ

1. Бүх өргөх төхөөрөмж болон өргөх механизмын эд анги, тэр дундаа бүрэлдэхүүн хэсэг, бэхэлгээ, тулгуур болон дэмжих эд анги нь:

(a) ашиглалтын шаардлага хангахуйц бат бөх, чанартай материалаар хийгдсэн байх;

(b) зориулалтын дагуу суурилагдсан, мөн ашиглагдах;

(c) хэвийн ажиллагаатай байх;

(d) үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд заасан нөхцөл, хугацаанд эрх бүхий этгээдээр туршилт болон үзлэг хийгдсэн байх, туршилт, үзлэгийн үр дүнг бүртгэдэг байх;

(e) үндэсний хууль тогтоомж болон журамд заасны дагуу зохих сургалтад хамрагдсан ажилтны дор ажиллуулах.

2. Үндэсний хууль тогтоомж болон журамд заасан зориулалтын дагуу баригдсан, суурилуулагдсан, ашиглагдах, түүнчлэн хүний биед ноцтой гэмтэл, эсхүл золгүй явдал гарч болзошгүй яаралтай нөхцөл байдал бий болсон, мөн өргөх төхөөрөмжийг аюулгүй ашиглах боломжтойгоос бусад тохиолдолд өргөх төхөөрөмжөөр хүнийг өргөх, буулгах, эсхүл тээвэрлэхгүй.

16 дугаар зүйл

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ БОЛОН АЧАА АЧИХ, БУУЛГАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

1. Тээврийн хэрэгсэл болон газар шорооны ажил гүйцэтгэх, эсхүл ачаа ачих, буулгах бүх тоног төхөөрөмж нь:

- (a) эргономикийн зарчмыг аль болох хангахуйц бүтэцтэй болон зохион бүтээгдсэн байх;
- (b) хэвийн ажиллагаатай байх;
- (c) зориулалтын дагуу ашиглагдах;
- (d) үндэсний хууль тогтоомж болон журамд заасны дагуу зохих сургалтад хамрагдсан ажилтны дор ажиллуулах зэрэг болно.

2. Барилгын бүх талбай дахь тээврийн хэрэгсэл, газар шорооны ажил гүйцэтгэх, эсхүл ачаа ачих, буулгах тоног төхөөрөмж нь:

- (a) тэдгээрт аюулгүй болон зохимжтой нэвтрэх арга замыг бүрдүүлэх,
- (b) аюулгүй үйл ажиллагааг хангах хүрээнд хөдөлгөөнийг хянах, зохион байгуулах зэрэг болно.

17 дугаар зүйл

СУУРЬ МАШИН, МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ГАР БАГАЖ

1. Механикжсан болон цахилгаан хөдөлгүүрт суурь машин, машин механизм болон тоног төхөөрөмж, тэр дундаа гар багаж нь:

- (a) эргономикийн зарчмыг аль болох хангахуйц зохион бүтээгдсэн, мөн бүтэцтэй байх;
- (b) хэвийн ажиллагаатай байх;
- (c) анхны зориулалтаас өөр зориулалтаар ашиглах нь аюулгүй гэж эрх бүхий этгээд дүгнэснээс өөрөөр заагаагүй бол зөвхөн зориулалтын дагуу ашиглана;
- (d) зохих сургалтад хамрагдсан ажилтны дор ажиллуулах зэрэг болно.

2. Үйлдвэрлэгч, эсхүл ажил олгогчоос аюулгүй ашиглалтын зааврыг хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар өгнө.

3. Үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд тодорхойлсон нөхцөл, хугацаанд даралтат суурь машин болон тоног төхөөрөмжийг эрх бүхий этгээдээр туршилт, үзлэг хийгдсэн байх зэрэг болно.



18 дугаар зүйл
ӨНДӨРТ АЖИЛЛАХ, ТЭР ДУНДАА ДЭЭВРИЙН АЖИЛ

1. Аюулаас сэргийлэх шаардлагатай, эсхүл байгууламжийн өндөр, эсхүл налуу нь үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд ажилтан болон багаж хэрэгсэл, эсхүл бусад зүйл, эсхүл эд материал унахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

2. Ажилтан дээвэр, эсхүл дээврийн ойролцоо, эсхүл эмзэг материалаар бүрхэгдсэн, унаж болзошгүй газар ажиллах шаардлагатай үед тухайн эмзэг материал дээр, эсхүл дундуур нь санамсаргүйгээр хөл тавьж унахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

19 дүгээр зүйл
СУУРИЙН НҮХ, ХУДАГ,
ГАЗАР ДЭЭРХ БОЛОН ДООРХ БАЙГУУЛАМЖ, НҮХЭН ГАРЦ

Аливаа суурийн нүх, худаг, газар дээрх болон доорх байгууламж, эсхүл нүхэн гарцад дараах зохих урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна. Үүнд:

(a) зохимжтой тулгуур бэхэлгээг хийх, эсхүл ажилтныг хөрс, чулуу, эсхүл бусад материалын нуралт, эсхүл тэдгээрээс унахаас сэргийлэх;

(b) суурийн нүх, худаг, газар дээрх болон доорх байгууламж, эсхүл нүхэн гарц руу ус түрж орох, эсхүл хүн, материал, эсхүл эд зүйлс унах аюулаас сэргийлэх;

(c) амьсгалах уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор зохих агааржуулалтаар хангах, утаа, хий, уур, тоос, эсхүл бусад бохирдлыг аюулгүй, эсхүл эрүүл мэндэд хор хөнөөлгүй түвшинд хязгаарлах, тэдгээрийг үндэсний хууль тогтоомж, эсхүл журмаар тогтоох;

(d) гал гарах, ус, эсхүл материал түрж орох үед ажилтныг аюулгүй газар хүрэх боломжийг бий болгох;

(e) газрын гүний ус шүүрэх, эсхүл хий ялгарах зэрэг газрын гүний аюул гарах тохиолдолд зохих хяналт шалгалтыг явуулж, тэдгээрийг илрүүлэх, ажилтанд учрах эрсдлээс зайлсхийх зэрэг болно.

20 дугаар зүйл
БАРИЛГЫН ЯЛУУ БА ХҮЧИТГЭСЭН БҮТЭЭЦИЙН АЖИЛ

1. Барилгын ялуу ба хүчитгэсэн бүтээц бүр нь:

(a) зориулалтаар ашиглахад шаардлага хангах бат бөх, чанартай материалаар хийгдсэн, зөв зохион бүтээгдсэн байх;

(b) ус, эсхүл материалд автах тохиолдолд ажилтныг аюулгүй газар хүрэх шаардлагатай хэрэгслээр тоногосон байх.

2. Барилгын ялуу ба хүчитгэсэн бүтээц барих, байрлуулах, өөрчлөх, эсхүл буулгах үйл ажиллагааг зөвхөн эрх бүхий ажилтны шууд хяналтан дор хийж гүйцэтгэнэ.

3. Барилгын ялуу ба хүчитгэсэн бүтээц эрх бүхий этгээд заасан хугацаанд тухай бүр шалгана.

21 дүгээр зүйл
ДАРЛТАТ АГААРТАЙ ОРЧИНД АЖИЛЛАХ

1. Даралтат агаартай орчинд зөвхөн үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд заасан арга хэмжээний дагуу ажиллана.

2. Зөвхөн бие бялдарын үзүүлэлтүүд нь эмнэлгийн үзлэг, шинжилгээгээр хэвийн гэж баталгаажсан ажилтан, мөн эрх бүхий этгээд үйл ажиллагааг удирдан явуулж байгаа байгаа тохиолдолд даралтат агаартай орчинд ажиллана.

22 дугаар зүйл
БАРИЛГА ХИЙЦ, БҮТЭЭЦИЙН ХҮРЭЭ БОЛОН ХЭЛБЭРЖҮҮЛЭЛТ

1. Барилгын үндсэн хийц, бүтээц, хүрээг зангидах болон хэв хашмал, тулгуур, бэхэлгээ угсрах ажлыг зөвхөн эрх бүхий ажилтны хяналтан дор гүйцэтгэнэ.

2. Ажилтныг байгууламжын хэврэг, эсхүл тогтворгүй байдлаас үүсэх аюулаас хамгаалах зохих арга хэмжээг авна.

3. Хэв хашмал, түүний бэхэлгээ болон тулгуур нь тэдгээрт үйлчлэх бүх ачааллыг бүрэн тэсвэрлэхээр зохион бүтээгдэж, баригдсан, мөн суурилагдсан байх.

23 дугаар зүйл
УСАН ДЭЭРХ АЖИЛЛАХ

Усан дээр, эсхүл усны ойролцоо ажиллахдаа дараах зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (a) ажилтныг ус руу унахаас сэргийлэх;
- (b) усанд живэх үед ажилтныг аврах;
- (c) аюулгүй тээврийн хэрэгсэл хангалттай тоо хэмжээгээр

байх.

24 дүгээр зүйл
БУУЛГАХ

Аливаа барилга, эсхүл байгууламжийг буулгах нь ажилтан, эсхүл олон нийтэд аюул учруулах бол:

(a) үндэсний хууль тогтоомж, эсхүл журмын дагуу хог хаягдал, эсхүл үлдэгдлийг зайлуулахдаа зохих урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон журмыг баталсан байна;

(b) тухайн ажлыг зөвхөн эрх бүхий ажилтны хяналтан дор төлөвлөж, гүйцэтгэнэ.



25 дугаар зүйл ГЭРЭЛТҮҮЛЭГ

Барилгын бүх ажлын талбай, мөн байгууламжийн бүс дэх бусад газар нь ажилтан зорчих боломжтой байх, мөн зохих гэрэлтүүлэг, шаардлагатай бол зөөврийн гэрэлтүүлгээр хангагдсан байх.

26 дугаар зүйл ЦАХИЛГААН

1. Бүх цахилгааны тоног төхөөрөмж болон тоноглолыг эрх бүхий ажилтан угсарч, суурилуулсан байх, мөн аюулаас сэргийлэх зорилготой байх.

2. Барилгын ажил эхлэхээс өмнө, мөн ажлын явцад газар доорх, эсхүл дээрх цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан дамжуулах шугам, эсхүл аппаратаас ажилтанд учрах аюулаас сэргийлэх зохих арга хэмжээг авна.

3. Барилгын талбайд цахилгаан дамжуулах шугам татах, аппарат суурилуулахдаа үндэсний хэмжээнд мөрдөгддөг техникийн дүрэм болон стандартыг баримтлана.

27 дугаар зүйл ТЭСЭРЧ, ДЭЛБЭРЭХ БОДИС

Тэсэрч, дэлбэрэх бодисыг дараах нөхцөлөөс бусад тохиолдолд хадгалах, тээвэрлэх, зөөх, эсхүл ашиглахгүй. Үүнд:

(а) зөвхөн үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд заасан нөхцөлд;

(б) ажилтан болон бусад хүмүүст гэмтэл учрах эрсдэл үүсэхгүй байх нөхцөлийг хангах эрх бүхий ажилтнаар гүйцэтгүүлэх бол.

28 дугаар зүйл ЭРҮҮЛ МЭНДЭД ТУЛГАРЧ БУЙ АЮУЛ

1. Хэрэв ажилтан аливаа хими, физик, эсхүл биологийн аюулд өртөж, тэр нь эрүүл мэндэд нь аюул учруулахаар бол тухайн нөлөөллөөс сэргийлэх шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ дараахаас бүрдэнэ. Үүнд:

(а) боломжтой бол аюултай бодисыг хор хөнөөлгүй, эсхүл аюул багатай бодисоор солих;

(б) суурин машин, машин механизм, тоног төхөөрөмж, эсхүл үйл ажиллагаанд техникийн арга хэмжээ авах;

(с) (а) болон (б) дэд хэсгийг дагаж мөрдөх боломжгүй бол бусад үр дүнтэй арга хэмжээ, тэр дундаа хувийн хамгаалах хэрэгсэл болон хамгаалах хувцсыг ашиглах.



3. Хэрэв ажилтан хортой болон аюултай бодис тархсан аливаа бүс, эсхүл хүчилтөрөгч дутагдсан, эсхүл галын аюултай нөхцөлд нэвтрэх шаардлагатай үед аюулаас сэргийлэх зохих арга хэмжээг авна.

4. Барилгын талбайн хог, хаягдлыг эрүүл мэндэд хор хөнөөл учруулахгүйгээр зайлуулахаас бусад тохиолдолд устгахгүй.

29 дүгээр зүйл **ГАЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ**

1. Ажил олгогч нь дараах зохих арга хэмжээг авна. Үүнд:

- (a) гал гаргах эрсдэлээс зайлсхийх;
- (b) гал алдах аюултай түргэн, үр дүнтэй тэмцэх;
- (c) хүмүүсийг түргэн шуурхай, аюулгүй нүүлгэн шилжүүлэх.

2. Шатамхай шингэн, хатуу болон хийг зохимжтой хадгалах хангалттай хадгалах байгууламжтай байх.

30 дугаар зүйл **ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ БОЛОН ХАМГААЛАХ ХУВЦАС**

1. Хэрэв осол гарах, эсхүл эрүүл мэндэд хор учруулах тааламжгүй нөхцөл бий болох эрсдэлээс сэргийлэх боломжгүй бол ажил олгогч нь үндэсний хууль тогтоомж, эсхүл журамд заасан ажил үүргийн онцлог, учирч болзошгүй эрсдэлийг харгалзан зохимжтой хувийн хамгаалах хэрэгсэл болон хамгаалах хувцсыг үнэ төлбөргүйгээр олгоно.

2. Ажил олгогч нь ажилчдыг хамгаалалтын шаардлагатай хэрэгслээр хангаж, зохистой хэрэглээг хангуулна.

3. Хамгаалах хэрэгсэл болон хамгаалах хувцас нь эргономикийн зарчмыг аль болох хангахуйц, эрх бүхий этгээдийн тогтоосон шаардлагад нийцсэн байна.

4. Ажилтнаас түүнд олгосон хувийн хамгаалах хэрэгсэл болон хамгаалах хувцсыг зөв хэрэглэх, хадгалахыг шаардана.

31 дүгээр зүйл **ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ**

Ажил олгогч нь эмнэлгийн анхны тусламж, тэр дундаа бэлтгэгдсэн ажилтныг ямагт бэлэн байлгах үүргийг хүлээнэ. Осол, эсхүл гэнэтийн өвчинд өртсөн ажилтанд эмнэлгийн тусламж үзүүлэх, нэн даруй эмнэлэгт шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.



32 дугаар зүйл
ХАНГАМЖ

1. Барилгын талбай бүр нийтийн ундны усны нөөцтэй байна.
2. Барилгын талбай бүр ажлын үргэлжлэх хугацаа болон ажилтны тооноос хамаарч дараах хэрэгслээр хангагдсан байна. Үүнд:
 - (a) ариун цэврийн болон угаалгын өрөө;
 - (b) хувцас солих болон хадгалах, мөн хатаах хэрэгсэл;
 - (c) цаг уурын таагүй нөхцөлөөс шалтгаалж ажил тасалдах үед байрлах байр болон хооллох өрөө зэрэг болно.
3. Эрэгтэй, эмэгтэй ажилтан ариун цэврийн болон угаалгын тусдаа өрөөгөөр хангагдсан байх.

33 дугаар зүйл
МЭДЭЭЛЭЛ БОЛОН СУРГАЛТ

- Ажилтан бүр:
- (a) ажлын байранд аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болзошгүй аюулын талаар мэдээлэл авсан;
 - (b) тэдгээр аюулаас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээний талаар зааварчилгаа авсан, бэлтгэгдсэн байх.

34 дүгээр зүйл
ОСОЛ, ӨВЧЛӨЛИЙН ТАЛААР ТАЙЛАГНАХ

Заасан хугацаанд эрх бүхий этгээдэд үйлдвэрлэлийн осол, өвчлөлийн талаар тайлагнахыг үндэсний хууль тогтоомж, эсхүл журмаар олгоно.

IV. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

35 дугаар зүйл

- Гишүүн улс бүр:
- (a) конвенцын заалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ, тэр дундаа зохих торгууль болон шийтгэл хүлээлгэж арга хэмжээ авах;
 - (b) конвенцын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг шалгах зохих хяналтын үйлчилгээг бий болгож, тус үйлчилгээгээр тэдгээр үүрэгт ажлыг гүйцэтгэх нөхцөл бололцоог хангах, эсхүл зохих хяналтыг хийх замаар үүргээ биелүүлнэ.

V. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

36 дугаар зүйл

Энэхүү конвенц нь Барилгын аюулгүй байдлын тухай 1937 оны конвенцын шинэчилсэн хувилбар болно.

37 дугаар зүйл

Энэхүү конвенцыг соёрхон баталсан тухай албан ёсны батламж жуух бичгийг бүртгүүлэхдээ Олон улсын хөдөлмөрийн товчооны даргад илгээнэ.

38 дугаар зүйл

1. Энэхүү конвенцыг зөвхөн соёрхон баталсан нь Олон улсын хөдөлмөрийн товчооны даргаар бүртгэгдсэн, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүн улс дагаж мөрдөнө.

2. Энэхүү конвенц нь хоёр гишүүн улс түүнийг соёрхон баталсан нь Олон улсын хөдөлмөрийн товчооны даргаар бүртгэгдсэнээс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

3. Цаашлаад, аливаа гишүүн улс түүнийг соёрхон баталснаа бүртгүүлснээс хойш арван хоёр сарын дараа энэхүү конвенц хүчин төгөлдөр үйлчилнэ.

39 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцыг соёрхон баталсан гишүүн улс нь конвенц анх хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван жил өнгөрсний дараа Олон улсын хөдөлмөрийн товчооны даргад тус конвенцыг цуцалж буй тухай мэдэгдлээ илгээснээр конвенцыг цуцалж болно.

Ингэж цуцлах нь бүртгүүлснээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү конвенцыг соёрхон баталсан гишүүн улс бүр өмнөх хэсэгт дурдсан арван жил өнгөрсний дараа нэг жилийн дотор энэ зүйлд заасны дагуу цуцлах эрхээ хэрэгжүүлээгүй бол тус конвенц дараагийн арван жилийн хугацаанд хүчинтэй хэвээр байх бөгөөд түүнээс хойш арван жилийн хугацаа өнгөрөх тутам энэ зүйлд заасан нөхцөлийн дагуу энэхүү конвенцыг цуцалж болно.

40 дүгээр зүйл

1. Олон улсын хөдөлмөрийн товчооны дарга Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүдэд энэхүү конвенцыг соёрхон баталсан болон цуцалсныг бүртгэсэн тухайгаа мэдэгдэнэ.

2. Хоёр дахь удаагаа соёрхон баталсан тухайг байгууллагын гишүүдэд мэдэгдэхдээ энэхүү конвенцыг хүчин төгөлдөр болох хугацааг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүдэд танилцуулна.

41 дүгээр зүйл

Олон улсын хөдөлмөрийн товчооны дарга энэхүү конвенцыг өмнөх зүйлд заасны дагуу соёрхон баталсан болон цуцалсныг бүртгэсэн



тухайгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бүртгүүлэхээр илгээнэ.

42 дугаар зүйл

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөл шаардлагатай гэж үзвэл энэхүү конвенцыг хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай тайланг Ерөнхий чуулганд танилцуулж, түүнийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн өөрчлөх тухай асуудлыг чуулганаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

43 дугаар зүйл

1. Тухайн конвенцид өөрөөр заагаагүй бол чуулганаар тус конвенцыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн өөрчлөх замаар конвенцыг шинээр баталсан тохиолдолд дараахыг баримтлана. Үүнд:

(a) гишүүн улс өөрчлөлт орсон конвенцыг соёрхон баталснаар шинэ конвенц хүчин төгөлдөр болох, эсхүл болох үед конвенцын 39 дүгээр зүйлийг үл харгалзан энэхүү конвенц нэн даруй цуцлагдана.

(b) өөрчлөлт орсон шинэ конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тус конвенцыг соёрхон батлах эрх нь гишүүн улсад нээлттэй болно.

2. Энэхүү конвенцыг соёрхон баталсан боловч өөрчлөлт орсон шинэ конвенцыг соёрхон баталж амжаагүй гишүүн улсын хувьд тус конвенц нь хэлбэр, агуулгын аль ч тохиолдолд хүчин төгөлдөр хэвээр байна.

44 дүгээр зүйл

Энэхүү конвенцын англи, франц хэлээр үйлдсэн эх бичвэр нь адил хүчинтэй байна.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2,25

Индекс: 200003